



Some Theoretical and Practical Issues of Defense Policy

Chuluun Battulga

Ph.D, Professor, Center for defense research, Defense Research Institute of Mongolia

E-mail address: chbtulga@gmail.com, ORCID:0009-0006-5928-6797

Received: 05 February 2026

Revised: 15 March 2026

Accepted: 23 March 2026

Published online: 30 March 2026



ABSTRACT

This article examines Mongolia's defense policy as a distinctive form of state policy, analyzing how it aligns at the theoretical level with widely used political and social science theories in international studies. Through comparative analysis, the study explains Mongolia's defense policy by drawing on practical examples of its implementation. Mongolia's defense policy incorporates elements of internationally recognized theoretical approaches, including Realism, Liberalism, Constructivism, Strategic Culture, and Comprehensive Security. This theoretical hybridity is largely shaped by Mongolia's unique geostrategic location.

Keywords: Security, defense, policy, strategy, international relations, security environment.

Батлан хамгаалах бодлогын онол, практикийн зарим асуудал

Чулуун Баттулга

Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Батлан хамгаалах судлалын

төвийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Ph.D), профессор,

chbtulga@gmail.com, ORCID:0009-0006-5928-6797

ХУРААНГУЙ

Энэхүү өгүүлэлд Монгол Улсын батлан хамгаалах бодлого нь төрийн бодлогын өвөрмөц хэлбэр болохын хувьд онолын талаасаа олон улсын хэмжээнд түгээмэл хэрэглэдэг улс төр, нийгмийн шинжлэх ухааны онол, үзэл баримтлалтай хэрхэн уялдаж байгааг харьцуулан судалж, манай улсын батлан хамгаалах бодлогыг хэрэгжүүлж буй практик үйл ажиллагааны жишээн дээр тайлбарласан. Монгол Улс Реализм, Либерализм, Конструктивизм, Стратегийн соёл, Цогц аюулгүй байдлын хандлага зэрэг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн онолуудын элементийг агуулсан батлан хамгаалах бодлогыг хэрэгжүүлж байгаа нь манай улсын гео-стратегийн байршлын өвөрмөц онцлогоос үүдэлтэй байна.

Түлхүүр үгс: аюулгүй байдал, батлан хамгаалах, бодлого, стратег, олон улсын харилцаа, аюулгүй байдлын орчин.

Оршил

Онолын талаас нь авч үзвэл “Батлан хамгаалах бодлого” гэж улс орны тусгаар

тогтнол, бүрэн эрхт байдал, газар нутгийн халдашгүй байдлыг хамгаалахтай холбоотой асуудлуудын талаар төрөөс баримтлах бодлогыг хэлнэ. Батлан хамгаалах судлал нь нийгэм, улс төрийн шинжлэх ухааны нэг судлагдахуун болох бөгөөд энэ талаар эрт үеэс өрнө, дорнын гүн ухаантан, сэтгэгчид Күнз (НТӨ 551-479 он), Сүнз (НТӨ 544-496 он), Платон (НТӨ 428/427-348/347 он), Аристотель (НТӨ 384-322 он) нар төр, нийгэм, засаглал, цэрэг, дайны асуудалд анхаарлаа хандуулж, сургаал, бүтээлээ туурвиж ирсэн байдаг (*Шижээ 2024*).

Улс орнуудын тусгаар тогтнол, тогтвортой байдалд учирч болох аюул эрсдлийн шинж чанар хувьсан өөрчлөгдөж байгаатай холбоотойгоор батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааны талаар баримтлах онол, үзэл баримтлал түүхэн хугацааны турш хувьсан өөрчлөгдөж байна. Улс орныг батлан хамгаалах бодлого, тогтолцоо нь улс төр, нийгэм, шинжлэх ухаан, технологийн шинжтэй аливаа өөрчлөлтөөс хамааран хувьсан өөрчлөгдөж байдаг динамик шинжтэй. Сүүлийн үеийн иргэний нийгэм, олон улсын цэрэг, улс төрийн байдалд гарч байгаа өөрчлөлттэй холбоотойгоор батлан хамгаалах арга хэмжээг дан ганц цэрэг хүчний байгууллагын хүрээнд хязгаарлахаа больж, бүх нийтийн оролцоонд тулгуурласан батлан хамгаалах нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх нь зүйтэй гэсэн хандлага түгээмэл болжээ.

Ардчилсан улсын хувьд батлан хамгаалах бодлогыг сонгуулиар олонх болж төрийн эрхийг барьж байгаа улс төрийн хүчин тодорхойлдог бөгөөд энэ бодлого нь үндэсний аюулгүй байдлыг хангах бодлогын хүрээнд гадаад бодлоготой нягт уялдаатай хэрэгждэг. Харин энэхүү бодлогыг хэрэгжүүлэгч нь Батлан хамгаалах яам буюу түүнтэй дүйцэхүйц үүрэгтэй төрийн байгууллага болон аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагууд байх ба энэ арга хэмжээнд цэрэг, хүчний байгууллагууд тэргүүлэх үүрэг гүйцэтгэдэг (*Дамзэвэг 2024*).

Дэлхийн улс орнуудын батлан хамгаалах бодлого, түүнийг хэрэгжүүлэх тогтолцоо тухайн улсын геостратегийн байршил, бүс нутгийн аюулгүй байдлын нөхцөл, хөрш орнуудын бодлого, стратеги, цэрэг-улс төрийн бодлого, нийгэм-улс төрийн тогтолцоо, эдийн засгийн хүчин чадал, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн түвшингээс хамаарч харилцан адилгүй байна. Өнөө үеийн дэлхийн олон улсын харилцаа, аюулгүй байдлын орчин, цэрэг-улс төрийн байдалд гарч байгаа томоохон өөрчлөлтүүдийн улмаас улс орнууд батлан хамгаалах бодлого, стратегийн баримт бичигтээ шинэчлэл, тодотгол хийх арга хэмжээнд ихээхэн анхаарал тавьж байна. Манай улс төрөөс батлан хамгаалах талаар баримтлах бодлогын баримт бичгээ тухайн үеийн нийгэм, улс төрийн тогтолцоо, олон улсын харилцаанд гарсан өөрчлөлттэй уялдуулан шинэчилж ирсэн байдаг (*Дамзэвэг 2024*).

Улс орныг батлан хамгаалах бодлого, арга хэмжээнд тодотгол хийх, шинэчлэх ажлыг амжилттай хэрэгжүүлэх үндэс нь шинжлэх ухааны онол, арга зүйд тулгуурлахад оршиж байдаг тул энэхүү өгүүллээр батлан хамгаалах бодлогын онол практикийн зарим асуудлыг талаарх судлаачийн байр суурийг уншигчидтай хуваалцахыг зорилго болгов.

Судалгааны арга зүй

Улс орнууд Батлан хамгаалах бодлогоо тодорхойлоход түгээмэл ашигладаг онол, арга зүйн асуудлыг судлан дүн шинжилгээ хийж, манай улсын өвөрмөц

онцлогт илүү нийцсэн онолын асуудлуудыг тусгайлан авч үзэж батлан хамгаалах талаар Монгол Улсын төрөөс баримталж байгаа бодлого, үйл ажиллагаатай эдгээр онолын асуудлууд хэрхэн уялдан зохицож байгааг тайлбарлахыг зорьсон болно.

Манай улсын батлан хамгаалах бодлогын шинэчлэл нь төрийн ардчилсан тогтолцоо, эдийн засгийн зах зээлийн харилцаа, нийгмийн шинэчлэл, олон улсын харилцааны өөрчлөлтөөс үүдэлтэйгээр эхэлсэн байдаг. Бодлогын баримт бичгийг анх 1994 онд “Монгол Улсын Цэргийн номлолын үндэс” нэртэйгээр гаргаж байсан бол 1998 онд түүнийг шинэчлэн “Монгол Улсын Төрийн цэргийн бодлогын үндэс” болгон өөрчилж, 2015 онд “Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс” нэгтэйгээр шинэчлэн баталж мөрдөж байна.

Хүчирхэг батлан хамгаалах тогтолцоог бүрдүүлсэн улсууд их төлөв хүчирхэг Зэвсэгт хүчинд тулгуурласан байдаг. Ийм улсууд гэвэл АНУ, ОХУ, БНХАУ, Их Британи, Франц зэрэг цэргийн хүчирхэг гүрнүүдийг нэрлэж болно. Цэргийн хүчирхэг гүрнүүдийн батлан хамгаалах тогтолцоог бүх төрлийн ай цэргээс бүрдэх дэлхийд тэргүүлэх зэвсэгт хүчин, цэрэг-эдийн засгийн хүчин чадал, нөөц, шинжлэх ухаан, технологи, аж үйлдвэрийн хөгжлийн түвшин бүрдүүлж байдаг.

Дэлхийн бусад буюу олонх улсуудын хувьд цэргийн эвсэл холбоонд нэгдэх, хүчирхэг гүрний ивээлд багтах замаар хамтын батлан хамгаалах тогтолцоог бүрдүүлэн аюулгүй байдлаа хангахыг зорьдог. Цөөн тооны зарим улс геостратегийн байршил, эдийн засгийн боломж, түүхэн уламжлал зэрэг хүчин зүйлээсээ хамааран “байнгын төвийг сахих статус” эсхүл “зэвсэгт хүчингүй улсын статус”-ыг зарлан тунхаглаж, бусад улс, олон улсын байгууллагаар хүлээн зөвшөөрүүлэх замаар гадны цэргийн аюулаас сэргийлэх бодлого баримталж байна (*Батмүлга and Даишэвэг 2025*).

Улс орныг батлан хамгаалах бодлого, стратегийг зөв тодорхойлохын тулд шинжлэх ухаанд суурилсан ул суурьтай судалгаа, дүн шинжилгээ хийхгүйгээр сайн бодлого, арга замыг боловсруулах боломжгүй гэдэгтэй маргах хүн үгүй бизээ. Батлан хамгаалах асуудал нь өөрөө нийгэм, улс төрийн шинжлэх ухааны нэг судлагдахуун болдог бөгөөд олон улсын харилцаа, улс орны аюулгүй байдлын асуудал улам бүр нарийн төвөгтэй, олон хүчин зүйлээс хамааралтай болж байгаагаас “Батлан хамгаалах судлал”-ыг хөгжүүлэх хэрэгцээ, шаардлагыг улам нэмэгдүүлж байна.

Аливаа улсын батлан хамгаалах бодлогын онолын үндэс нь олон улсын харилцаа, стратег судлал, аюулгүй байдал судлал, улс төрийн шинжлэх ухаан, цэргийн урлаг, цэргийн шинжлэх ухаан зэрэг улс төр-нийгмийн шинжлэх ухааны олон салбарыг хамарсан онол арга зүйд тулгуурласан байдаг. Дэлхийн улс орнуудын батлан хамгаалах бодлогод түгээмэл ашиглаж байгаа онолуудаас манай орны онцлогт тохирох зарим онолыг авч үзлээ.

1. Реализмын онол (Realism - Classical & Neorealism): өөрийн эрх ашгийг тэргүүнд тавих

Эртний философичид, тухайлбал Фукидид, Никколо Макиавелли, Томас Хоббс нарыг энэхүү онолыг үндэслэгчид гэж үздэг. Реализмын онолын дагуу улс орнууд нэгдмэл засаг захиргаагүй, эмх замбараагүй /анархи/ олон улсын орчинд өөрийн аюулгүй байдал, бүрэн эрхийг хамгаалах өөрийн ашиг сонирхлыг тэргүүнд

тавьж, үүний тулд цэрэг, улс төрийн бүхий л арга хэрэгслийг ашиглахад чиглэсэн бодлого явуулах болно. Орчин үеийн реализм XX зууны дунд үеэс үүсэж, Дэлхийн II дайн болон Хүйтэн дайн-ын нөхцөлд онолын хувьд боловсорсон. Энэ онолын гол төлөөлөгчид гэвэл Томас Хоббс, Ханс Моргентау (Hobbes, Morgenthau) – сонгодог реализм, Кеннет Уолтц (Kenneth Waltz) – неореализм (Structural Realism) нарыг дурдаж болно. Энэ онол улс орнууд олон улсын төвлөрсөн засаглалгүй (анархи) системд өөрсдийгөө хамгаалах ёстой, үүний тулд ашиг сонирхлоо хамгаалах хүч хамгийн чухал. Иймд дайн, өрсөлдөөн бол олон улсын харилцааны зайлшгүй хэсэг байх болно гэсэн үзэл санаанд тулгуурлана. Реализм нь дотроо Түрэмгий (Offensive) реализм (Джон Миршаймер) “цэргийн хүчийг нэмэгдүүлэх замаар аюулгүй байдлаа хангах” ба Хамгаалах (Defensive) реализм (Кеннет Уолц) “цэргээр хэт хөөцөлдөх нь тэнцвэрийг алдагдуулах учир хэрэгцээнд тохирсон зохистой хэмжээний батлан хамгаалах чадавхийг бүрдүүлэх замаар аюулгүй байдлаа хангах нь зүйтэй” гэсэн хоёр чиглэлтэй байдаг.

Энэ онолын үүднээс авч үзвэл улс, гүрэн үндэсний ашиг сонирхлоо хангах, хамгаалахын тулд цэргийн хүчээ бэхжүүлэх, цэргийн эвсэл холбоо байгуулахад чиглэсэн батлан хамгаалах бодлого хэрэгжүүлнэ. Батлан хамгаалах хүч чадлаа нэмэгдүүлэхэд ихээхэн анхаарал тавьж байгаа БНХАУ, БНАСАУ, ОХУ болон НАТО зэрэг цэргийн эвслийг энэ бодлогын жишээ гэхэд болно.

2. Либерализм (Liberal Institutionalism): олон улсын хамтын ажиллагаа, энхийг эрхэмлэсэн бодлого

XVII–XVIII зуунаас бүгд тэгш эрхтэй байх, хүний эрх, эрх чөлөөнд төрийн оролцоог хязгаарлах үзэл санаан дээр үндэслэсэн улс төр, ёс суртахууны онол (философ) юм. Нийгмийн хөгжлийн явцад бодит амьдралд бүрэн хэрэгжих бололцоо хязгаарлагдмал байснаас шалтгаалан 1930-аад оноос төрийн нийгэм-улс төрийн оролцоог хүлээн зөвшөөрсөн зарим нэг зүйлээр шинэчлэгдэн 20-р зууны дунд үед Неолиберализм буюу либерал институцын онол болон хөгжсөн байна. Энэ онолын гол төлөөлөгчид нь Иммануил Кант (Мөнхийн энхийн онол), Роберт Кеохэйн, Жозеф Най (Неолиберализм) нар болно.

Гол үзэл санаа: олон улсын байгууллагууд, улс орнуудын хамтын ажиллагаа, эдийн засгийн харилцан хамаарал нь дайн, зөрчилдөөнөөс урьдчилан сэргийлэх нөхцөл болж энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэхэд тусална. Ардчилсан орнууд нэгнийхээ эсрэг дайн өдөөхгүй (Democratic Peace Theory). Манай улсын дэлхийн бүх улстай найрсаг харилцааг хадгалах, аливаа маргаантай асуудлыг шийдвэрлэхэд улс төр дипломатын аргыг урьтал болгоно гэсэн энхийг эрхэмлэсэн бодлого нь энэ онолын нэг жишээ болно.

3. Конструктивизм (Constructivism)

Нийгмийн шинжлэх ухааны зарим асуудлыг реализм болон либерализмийн онолоор тайлбарлахад учир дутагдалтай байсантай холбоотойгоор 1980-аад оны сүүл, 1990-ээд оны эхээр конструктивизмын онол олон улсын харилцаанд гарч ирсэн. Энэ онол олон улсын харилцаанд дайн, энхийн асуудал нь улс орнуудын түүх, соёл, уламжлал, үнэт зүйл, бусдыг ойлгож танин мэдэх, хүлээн зөвшөөрөх зэрэг нийгмийн хандлагаас үүдэлтэй гэсэн хандлагаар хүч чадлаас илүү үзэл, санаа чухал үүрэг гүйцэтгэнэ гэсэн байр суурийг үндэс болгодог. Үүгээрээ олон улсын

харилцааны үндсэн асуудлууд материаллаг гэхээсээ илүүтэй нийгмийн шинжийг агуулна гэж үздэг.

Иймээс аюулгүй байдлын талаарх ойлголт нь соёл, эрх ашиг зэрэг нь нийгмийн хөгжил, хувьслын үр дүнд бий болдог үзэгдэл болох ба улс орнуудын асуудалд хэрхэн хандах, хариу үйлдэл үзүүлэх нь бодит аюул заналаас бус, харин түүнийг хэрхэн ойлгож байгаас хамаарна. Конструктивизмын үүднээс авч үзвэл батлан хамгаалах бодолго нь үндэсний онцлог, улс төрийн соёл, аюул заналын талаарх нийгмийн ойлголт, хандлагын илрэл байна. Энэ онолын гол төлөөлөгчид гэвэл Александр Вендт, Марта Финнемор, Питер Катценстайн нарыг нэрлэж болно.

4. Стратегийн соёл (Strategic Culture): Түүхэн уламжлал, шинэчлэл, соёлын нөлөө

Стратегийн соёлын зарим асуудлыг эртний гүн ухаантнууд (Сүнз, Фукидид)-ын зохиол бүтээлд анх хөндсөн байдаг бол улмаар эртний Ром, Наполеоны дайн, Дэлхийн II дайн, хүйтэн дайны эрин үед улам боловсронгуй болж хөгжсөн гэж үздэг. Стратегийн соёл ба улс төрийн соёл нь тусдаа ойлголт бөгөөд “стратегийн соёл” нь улс хоорондын өрсөлдөөн, дайн зэвсэгт тэмцлийг явуулахад улс үндэстний соёл уламжлалаас үүдэлтэй онцлог, нөлөөний асуудлыг авч үздэг бол “улс төрийн соёл” нь улс төрийн систем дэх хүчнүүдийн харилцааны асуудалд анхаарал хандуулдаг байна. Стратегийн соёлын талаарх онолын гол бүтээлийг АНУ-ын улс төр судлаач Жэк Снайдер (Jack Snyder) (*Snyder 1977*) 1970-аад онд АНУ, ЗХУ-ын цөмийн стратегийг харьцуулан судалсны үр дүнд туурвижээ. Стратегийн соёлын онолын гол үзэл санаа нь улс орнуудын батлан хамгаалах бодлого зөвхөн геополитик, улс төр, эдийн засгаас гадна үндэсний үнэт зүйлс, түүх, соёл, уламжлалаас хамаарна. Тухайлах юм бол цэргийн хүч хэрэглэх нөхцөл, хэлбэр, тэр ч бүү хэл дайныг ойлгох байдал хүртэл үндэсний соёлоос хамааран ялгаатай байдаг гэж үздэг. Иймээс батлан хамгаалах бодлогын үндсэн чиглэлүүд (дайн, аюул заналын талаарх ойлголт, холбоотон гэх мэт)-ийн талаарх хандлага, байр суурь тухайн улс, үндэстний түүх, соёл уламжлалд нэгэнт суусан байдаг аж. Жэк Снайдер, Колин Грэй, Кен Бут нарыг энэ онолын гол төлөөлөгчид гэж үздэг байна.

5. Цогц аюулгүй байдлын хандлага (Comprehensive Security)

Хүн төрөлхтний нийгмийн хөгжлийн явцад хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотойгоор, хүний аюулгүй амьдарч аж төрөх эрхийн асуудалд олон улсын байгууллагуудын зүгээс ихээхэн анхаарал хандуулах болсон. Улмаар 1994 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр (UNDP)-өөс гаргасан “Хүний хөгжлийн тайлан”-д хүн төвтэй, түүний амьдралын чанар, сайн сайхан, эрх чөлөө, аюулгүй, байдлыг хангах үзэл баримтлалын талаарх ойлголтыг анх тодорхойлж, эдийн засаг, хүнс, эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, олон нийтийн болон улс төрийн тогтолцооны хүрээнд хувь хүний аюулгүй байдлыг хангахыг уриалсан байдаг. Ингээд 2000-аад оноос хойш аюулгүй байдлыг хангах нь уламжлалт дайн цэргийн үйл ажиллагаанд голлосон хандлагаас хүний амьдралын чанарыг сайжруулахад чиглэсэн эдийн засаг, хүнс, эрүүл мэнд, байгаль орчин зэрэг асуудлууд руу тэлсэн. Энэ онолыг хөгжүүлэгчид гэвэл Барри Бузан (Barry Buzan), Роланд Парис (Roland Paris), НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Хүний аюулгүй байдлын комисс (UNDP Human Security Commission) зэргийг дурдаж болно.

Энэ онолын гол үзэл санаа нь аюулгүй байдал гэдэг нь зөвхөн цэрэг армийн хүчээр улсын хил, газар нутгийг хамгаалахаар хязгаарлагдахгүй харин иргэн хүний эрх, амьдрах орчин, суурь хэрэгцээний баталгааг хангах ёстой гэж үздэг. Үүнээс уламжлан улс орныг батлан хамгаалах бодлого “аюулгүй байдал”-ын талаарх уламжлалт ойлголтыг өргөжүүлж, хувь хүн төвтэй, түүнийг бүх талаар хамгаалсан, цогц хандлагыг төлөвшүүлэхэд чиглэх болсон.

Судалгааны үр дүн

Монгол Улс нь Евразийн төв хэсэгт орших, хоёр их гүрэн Орос, Хятадын дунд байрлах геополитикийн эмзэг байршилтай, далайд гарцгүй улс билээ. Энэ онцлог нь Монгол Улсын батлан хамгаалах бодлогод нөлөөлөх гол хүчин зүйлсийн нэг бөгөөд түүний стратеги төлөвлөлт нь олон улсын харилцааны онолуудад үндэслэдэг. Монгол Улс нь эвсэлд үл нэгдэх, энхийг эрхэмлэсэн гадаад бодлого баримталж, олон улсын хамтын ажиллагаанд тулгуурлахын зэрэгцээ гуравдагч хөршийн бодлогыг идэвхтэй хэрэгжүүлдэг. Иймээс Монгол Улсын батлан хамгаалах бодлогыг реализм, либерализм, конструктивизм, стратегийн соёл болон цогц аюулгүй байдлын онолуудын хүрээнд авч үзэх боломжтой.

Реализмын онолын дагуу улс орнууд олон улсын нэгдмэл засаг захиргаагүй, эмх замбараагүй /анархи/ орчинд өөрийн аюулгүй байдал, бүрэн эрхийг хамгаалах өөрийн ашиг сонирхлыг тэргүүнд тавьж, үүний тулд цэрэг, улс төрийн бүхий л арга хэрэгслийг ашиглахад чиглэсэн бодлого явуулдаг (*Waltz 1979*). Монгол Улс нь аливаа цэргийн эвсэлд элсэхээс зайлсхийж, гадаадын цэргийн бааз байрлуулахгүй байх зарчмыг чанд баримталдаг. Энэ нь тус улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлаа өөрийн хүчинд тулгуурлан хангах стратеги, бодлогын илэрхийлэл юм (*Tsedendamba 2021*).

Либерализмын онол нь олон улсын байгууллага, хамтын ажиллагаа нь аюулгүй байдлыг хангахад чухал үүрэгтэй гэж үздэг (*Robert O and Nye 1977*). Монгол Улс нь НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд идэвхтэй оролцдог бөгөөд “гуравдагч хөрш”-ийн бодлогоор дамжуулан АНУ, Япон, Европын холбоо зэрэг ардчилсан орнуудтай стратегийн харилцаа тогтоож, батлан хамгаалах салбарт хамтран ажиллаж байна (*Waltz 1979*). Энэ нь Монгол Улсын энхийг эрхэмлэсэн дүр төрхийг олон улсад таниулсан бөгөөд олон улсын хамтын нийгэмлэгийн идэвхтэй, хариуцлагатай гишүүн болгож олон улсын хэмжээнд тусгаар тогтнол, аюулгүй байдлаа бэхжүүлэх бодлогын илрэл болдог. Энэхүү бодлого нь Монгол Улсын энхийг эрхэмлэсэн байр суурийг бататгаж, олон улсын хамтын нийгэмлэгийн гишүүн орны хувьд итгэлцэл, дэмжлэг олж авах нөхцөлийг бүрдүүлж байна

Конструктивизмын онолоор аюулгүй байдал нь дан ганц бодит занал аюулаар бус, тухайн улсын дүр төрх, үнэт зүйлс, олон нийтийн ойлголт, хүлээн зөвшөөрөгдөх байдал дээр суурилдаг гэж үздэг (*Wendt 1992*). Монгол Улс нь цөмийн зэвсэггүй бүс хэмээн өөрийгөө тунхаглаж, бүс нутгийн энх тайван, яриа хэлэлцээний санаачилгуудыг дэмжиж, Улаанбаатарын яриа хэлэлцээг зохион байгуулдаг (*Batsaikhan 2023*). Үүгээрээ Монгол Улс өөрийгөө энхийн зуучлагч, зөрчилдөөний гадуурх улс гэдэг дүр төрхийг бүрдүүлдэг. Энэхүү энхийн байр суурь нь Монгол Улсыг хөршүүд болон олон улсын хамтын нийгэмлэгийн дунд найдвартай, зөөлөн хүчний жишиг улс гэсэн ойлголтыг бий болгох нь Монголын

аюулгүй байдлын нэгэн чухал тулгуур багана болдог.

Стратегийн соёлын онолоор аливаа улс, гүрний түүхэн туршлага, уламжлал, соёлын үнэт зүйлс нь тухайн улсын батлан хамгаалах бодлогоо тодорхойлох хандлагад гүн нөлөө үзүүлдэг чухал хүчин зүйлд тооцдог (*Colin S, n.d.*). Шинэ үеийн Монголын зэвсэгт хүчин нь Зөвлөлтийн тогтолцооны суурь дээр хөгжсөн ч сүүлийн жилүүдэд орчин үеийн шинэчлэлийг эрчимтэй нэвтрүүлж байна. Монголын зэвсэгт хүчин эртнээс уламжилж ирсэн монгол цэргийн агуу түүх, соёл, уламжлал, бахархлыг залгамжлан үргэлжлүүлэхийн зэрэгцээ уламжлалт бус цэргийн ажиллагааны шинэ чиглэлүүд /гамшигтай тэмцэх, энхийг сахиулах, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх гэх мэт/-ийг соргогоор тусган авч сургалт, бэлтгэлийнхээ агуулга, цар хүрээг өргөжүүлж байгаа нь стратегийн соёлын илрэл юм.

Монгол Улсын батлан хамгаалах бодлого нь Зэвсэгт хүчин, цэрэг зэвсгийн хүчээр өөрийгөө хамгаалах уламжлалт ойлголтоос хальж “Цогц аюулгүй байдлын хандлага” буюу эдийн засаг, байгаль орчин, эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал зэрэг цогц хандлага руу чиглэн хөгжиж, бүх нийтийн оролцоотой батлан хамгаалах нэгдмэл тогтолцоог бүрдүүлэхэд анхаарч байна (*“Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын Үзэл Баримтлал” 2010*). Зэвсэгт хүчний тухай хуульд гамшигийн үед аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох, хүмүүнлэгийн тусламж, улсын онц чухал объектыг хамгаалах, хүн амыг сургаж бэлтгэх, тэдэнд эх оронч үзлийг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх, бүтээн байгуулалтын ажилд оролцох зэрэг чиг үүргийг нэмж оруулсан. Энэ нь Монгол Улсын аюулгүй байдлыг зөвхөн цэрэг зэвсэгтэй холбон ойлгох хандлагыг халж, олон талт хандлагаар үндэсний тогтвортой байдлыг цогцоор хангах стратеги болон өргөжиж байгаагийн илрэл болно (*“Монгол Улсын Батлан Хамгаалах Бодлогын Үндэс” 2015*).

ДУГНЭЛТ

Энэ бүхнээс үзвэл Монгол Улсын батлан хамгаалах бодлого нь олон улсын аюулгүй байдлын гол онолуудтай уялдаатайгаар хэрэгжиж байна. Монгол Улсын батлан хамгаалах бодлогын агуулгад илэрч буй асуудлууд: геополитикийн эмзэг байршил, түүхэн туршлага, үндэсний үнэт зүйлс, энхийг эрхэмлэсэн байр суурь гуравдагч хөршийн бодлого зэрэг нь реализм, либерализм, конструктивизм болон стратегийн соёлын онолуудын тусгал гэж үзэх бүрэн үндэстэй. Эдгээр онолуудыг хослуулан хэрэглэх нь Монгол Улсыг бие даасан, зөөлөн хүчийг эрхэмлэсэн, хамтын ажиллагаанд суурилсан, төвийг сахисан, олон талт аюул, эрсдэл бүхий орчинд бэлтгэлтэй байхад чиглэсэн батлан хамгаалах бодлого баримталдаг улс хэмээн үзэх үндэс суурь болох юм.

Монгол Улсын батлан хамгаалах бодлогыг олон улсын харилцааны онолын эрсдэлийг давхар удирдах (hedging) стратегийн өвөрмөц жишээ гэж бас үзэж болно. Энэ стратегийг олон улсын практикт хүч чадал нь өсөж буй ч зорилго, санаархал нь бүрэн тодорхойгүй их гүрнүүдтэй харилцах үед өргөн хэрэглэдэг. Монгол Улсын хоёр их гүрний дунд оршдог, далайд гарцгүй, батлан хамгаалах хязгаарлагдмал чадавхтай, эдийн засаг хөрш орнуудаас өндөр хамааралтай байдал нь ийм стратег баримтлах зайлшгүй нөхцөл гэхэд болно.

Монгол Улс олон улсын харилцааны идэвхтэй оролцоо ба итгэлцэл,

эдийн засгийн хамтын ажиллагаа, аюулгүй байдлын аливаа зөрчилдөөнөөс зайлсхийх, гуравдагч хөршийн бодлого, батлан хамгаалахын хамтын ажиллагаа, энхийг сахиулах идэвх санаачилга, цэргийн эвсэлд үл нэгдэх, гадаадын цэрэг байрлуулахгүй, цөмийн зэвсэггүй статус, энх тайвныг зуучлагчийн имиж бүрдүүлэх замаар цэргийн бус аргаар аюулгүй байдлын баталгаагаа хангах бодлого зэрэг нь дээр дурдсан онолуудыг өөрийн орны онцлогт зохицуулан ухаалгаар ашиглаж байгаагаараа “hedging” стратегийг амжилттай хэрэгжүүлж байгаа гэж дүгнэх боломжтой юм.

Эшлэл авсан сурвалж, судалгааны бүтээл:

1. Batsaikhan, S. 2023. “Peace Diplomacy and Mongolia’s Soft Power Identity.” *Journal of Northeast Asian Peace and Security* 4 (2): 51–64.
2. Colin S, Gray. n.d. *Modern Strategy*. Oxford UP.
3. Robert O, Keohane, and Joseph S. Nye. 1977. *Power and Interdependence: World Politics in Transition*. Little, Brown.
4. Snyder, Jack L. 1977. *The Soviet Strategic Culture. Implications for Limited Nuclear Operations*. Rand Corporation.
5. Tsendendamba, T. 2021. *Neutrality and National Defense in Mongolian Security Policy*. Vol. 8. Central Asian Affairs. Central Asian Affairs.
6. Waltz, Kenneth N. 1979. *Theory of International Politics*. Addison-Wesley.
7. Wendt, Alexander. 1992. *Anarchy Is What States Make of It: The Social Construction of Power Politics*. Vol. 46. International Organization.
8. Баттулга, Чулуун, and Цэрэнбалжид Дашзэвэг. 2025. *Батлан Хамгаалах Бодлогын Хувьсал, Өөрчлөлт*. Соёмбо принтинг.
9. Дашзэвэг, Цэрэнбалжид. 2024. *Батлан Хамгаалах Тогтолцоо Бэхжүүлэх Зарим Асуудалд*. Соёмбо принтинг.
10. “Монгол Улсын Батлан Хамгаалах Бодлогын Үндэс.” 2015. Government Document. Government of Mongolia.
11. “Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын Үзэл Баримтлал.” 2010. Government Document. Government of Mongolia.
12. Шижээ, Паламдорж. 2024. *Батлан Хамгаалах Судлал: Онол Практикийн Асуудлаар Эрдэм Шинжилгээний Өгүүллийн Эмхэтгэл*. Соёмбо принтинг.